



ГОВЬСУМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 1/09

Шивээговь сум

Эд хөрөнгө худалдаж авахад  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолын хавсралт “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Сумын Засаг даргын Тамгын газарт камерийн тоног төхөөрөмж худалдаж авахад 9,820,000 (есөн сая найман зуун хорин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Эд хөрөнгө худалдаж авах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Зардалд зарцуулагдах 9,820,000 (есөн сая найман зуун хорин мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын “Бараа үйлчилгээний бусад зардал”-аас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

4. Холбогдох ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа), нярав (Б.Баярцэцэг) нарт үүрэг болгосугай.



ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ